



УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ

2019 оны 05 сарын 06 өдөр

Дугаар 2153

Улаанбаатар хот


Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.2, 16.5.5, Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.3 дахь заалт, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан “Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам”-ын 2 дугаар бүлгийн 2.4.1, Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн 2019 оны батлагдсан төсвийн хүрээнд Төвлөрсөн хогийн цэгийг хөрсөөр дарж булах, Алтан Өлгийн оршуулгын газрын арчлах хамгаалах, Устгасан нохой, муурын сэг зэмийг шатаах, дарж булах, Нийтийн бие засах газруудын ашиглалт зэрэг ажлуудыг зохион байгуулж ажиллахыг Тохижилт, хог хаягдлын удирдлагын хэлтэс /Г.Ууганбаяр/-т үүрэг болгосугай.

2. Төвлөрсөн хогийн цэгийг хөрсөөр дарж булах ажилд шаардагдах 2.080.000.000 /Хоёр тэрбум наян сая/, Устгасан нохой, муурын сэг зэмийг шатаах, дарж булах ажилд шаардагдах 248.000.000 / Хоёр зуун дөчин найман сая/, Алтан Өлгийн оршуулгын газрын арчлалт хамгаалалтын ажилд шаардагдах 79.000.000 /Далан есөн сая/, Нийтийн бие засах газруудыг ажиллуулахад шаардагдах 126.540.000 /Нэг зуун хорин зургаан сая таван зуун дөчин мянга/ төгрөгийг хот тохижилтын төсөвлөгдсөн зардлаас тус тус гүйцэтгэлээр санхүүжүүлж ажиллахыг Ахлах нягтлан бодогч Б.Цэрмаад зөвшөөрсүгэй.

3. Дээр дурдсан ажлын захиалагчийн хяналт тавьж ажилласан хөндлөнгийн хяналтын Төрийн бус байгууллагын санхүүжилтийг ажил тус бүрийн батлагдсан төсвийн 2%-аар тооцож олгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

